

Боловсруулах үйлдвэрийн байгууламж, дэд бүтэц элэгдэж хуучрах

2018 оны 5-р сар

Боловсруулах үйлдвэрүүдийн хувьд барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмж элэгдэж хуучрах нь аюулгүй ажиллагааны нэг ноцтой асуудал юм.

2010 онд АНУ-ын Вашингтон мужийн тос боловсруулах үйлдвэрт асар хүчтэй дэлбэрэлт тохиолдсон. (1). Ялтсан бойлерын хуяг задарч сүйрсэн бөгөөд долоон хүн амь насаа алдсан. Тус бойлерыг бараг 38 жил ашигласан байсан ба өндөр температур болон даралттай устөрөгчийн нөлөөнд тогтмол өртсөний улмаас ган хуягны гадаргуу цууралтууд үүссэн байжээ. Боловсруулах үйлдвэрийг анх барих үед дээрх эрсдлийн механизмын (өндөр даралттай устөрөгчийн идэлт) талаар бүрэн ойлголтгүй байсан ба хамгийн сүүлд 12 жилийн өмнө хуягийн гадаргууд үзлэг хийхэд цууралт илрээгүй аж.

Өөр нэг ослын үед тос боловсруулах үйлдвэрийн хонгилын дээвэр нурж, тоног төхөөрөмжид том хэмжээний хохирол учруулсан. Азаар хүн гэмтэж бэртээгүй. Дээврийн дотор хэсгийн дам нуруунууд хорь орчим жилийн турш доор нь байрлах тоног төхөөрөмжөөс ялгарах ууранд өртсөн байна. Дээвэр дээрх цас, борооны ус төхөөрөмжийн ууртай конденсацлагдаж, дам нуруунд зэврэлт үүсгэсэн. Эцэст нь нэгэн өвөл ихээхэн хэмжээний цас орох үед дээвэр нурсан. Тус үйлдвэрт барилга байшингийн засвар үйлчилгээг хариуцахаар томилогдсон хүн огт байгаагүй. Операторууд боловсруулах процессын тоног төхөөрөмжүүдээс илүү зүйлсэд тогтмол анхаарал хандуулаагүй. Энэхүү осол тухайн тоног төхөөрөмж нь үйлдвэрийн боловсруулах процесст ашиглагддаг химийн бодист шууд өртдөг эсэхээс үл хамааран бүх барилга байгууламж, дэд бүтцийн хувьд засвар үйлчилгээ ямар чухал болохыг илтгэж байгаа юм.



Элэгдэж хуучирсан тоног төхөөрөмжийн жишээ:

2. Силос/нөөцлөх сав
3. Шигшүүр
4. Цистерн машин

Та мэдэх үү?

- Боловсруулах үйлдвэрийн бүх байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хувьд элэгдэж хуучрах процесс нь тэдгээрийн нөхцөл, бүрэн бүтэн байдалд нөлөөлдөг.
- Хэвийн үйл ажиллагааны нөхцөлд сөрөг нөлөө удаан хугацаанд үргэлжлэх, үе үе доголдох нь тоног төхөөрөмжийн чанарыг доройтуулж, эрсдэлд өртөх боломжийг улам нэмэгдүүлдэг.
- Маш олон үйлдвэр барилгын үе шатанд анх тооцоолсон хэмжээнээсээ өөр түвшин, нөхцөлд үйл ажиллагаа явуулдаг.
- Элэгдэж хуучрах процесс нь тухайн байгууламж, тоног төхөөрөмж хэр зэрэг шинэ, хуучин гэдгээс заавал хамаарахгүй. Харин ашиглалт ба засвар үйлчилгээ хэр сайн байсантай л холбоотой. Элэгдэж хуучрах процесс бол хувирч өөрчлөгдөх явц бөгөөд үйлдвэрийн ажилчдыг анхааралтай, сэрэмжтэй байхыг шаарддаг.

Та юу хийж чадах вэ?

- Бүх байгууламж, тоног төхөөрөмжийг аюулгүй ажиллагааны тусгай заасан хэм хэмжээнд нь ажиллуулах;
- Аюулгүй ажиллагааны заасан хэм хэмжээ гажсан тохиолдлыг удирдлагад мэдэгдэх хэрэгтэй ба техникийн мэргэжилтнүүд тухайн гажилтын улмаас төхөөрөмжид учирч болзошгүй нөлөөллийг үнэлж дүгнэнэ.
- Үйлдвэр, байгууламжийн өдөр тутмын үзлэгийн үед ямар нэгэн хэвийн бус нөхцөл эсвэл тоног төхөөрөмжийн чанарыг дордуулсан шинж тэмдэг байгаа эсэхийг ажигла.
- Үйлдвэрийн талбайд зөвхөн өөрийн хариуцсан хэсгээр хязгаарлагдахгүйгээр ажиглалт хий. Жишээ нь: Сараалжин тавцан, төмөр замын хашлага, шугам хоолойн гүүрний тулгуур, байшингийн арматур болон бусад дэд бүтцийг албан ёсны үзлэгийн үед орхигдуулах боломжтой.
- Ямар нэгэн ноцтой зүйлийг ахлах ажилтан, удирдлагадаа мэдэгд.

Тоног төхөөрөмжийг элэгдэж хуучрахаас сэргийлэхэд арчилгаа шаардлагатай!